

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

2019 ОНЫ 04 САРЫН 24 ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04-р сарын 24-ний өдөр

Хархорин сум

“Хархорин” нээлттэй ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04-р сарын 24-ний өдөр 14 цаг 00 минутад Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ толгой баг, Усжуулахын контор хаягаар байрлах Хархорин ХК-ийн хурлын танхимд эхлэв.

Хуралд оролцсон Хувьцаа эзэмшигчид

1. С.Пүрэв – “Хархорин” ХК-ийн 377,660 ш хувьцаа эзэмшигч (саналын хуудсаар оролцсон)
2. Д. Дашмаа- Ерөнхий нягтлан бодогч, Хувьцаа эзэмшигч (100 ширхэг хувьцаатай)
3. Ц. Баасансүрэн - Хувьцаа эзэмшигч (100 ш)
4. Ч. Отгонсүрэн - Хувьцаа эзэмшигч (93 ш)

Хуралд байлцсан бусад хүмүүс:

1. П.Бишрэл - Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга
2. Р.Саранцэцэг - Гүйцэтгэх захирал
3. Б. Ганбат – Хурал зохион байгуулах комиссын дарга
4. Э.Ариунаа – Хурал зохион байгуулах комиссын гишүүн
5. М.Шавагцэрэн - Тооллогын комиссын дарга
6. Г.Баярмаа – Тооллогын комиссын гишүүн
7. Л.Бямбасүрэн - Ерөнхий агрономич

Түүнчлэн компанийн бусад ажилтан ажиллагсад оролцсон болно.

Хурлын ирц: Нийт 539,515 ш хувьцаа эзэмшиж байгаа 575 хувьцаа эзэмшигч хуралд оролцохоос 377.953 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшиж байгаа 4 хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хурлын ирц 70.05 % болсон (Компанийн тухай хуулийн дагуу саналын хуудсаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигч С.Пүрэвийг тус хуралд оролцсон тооцов).

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;



2. Компанийн 2018 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах;
4. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

Хэлэлцсэн байдал:

Тооллогын комиссын зүгээс хурлын ирцийг танилцуулсан болно.

Хархорин ХК-ийн Хувьцаа эзэмшигчидийн ээлжит хуралд нийтдээ 539,515 ш хувьцаа эзэмшиж байгаа нийт 575 хувьцаа эзэмшигч ирэхээс 377,953 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 4 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Компаний саналын эрх бүхий нийт хувьцааны 70.05 %-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн. Иймд компаний тухай хууль болон компаний дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж үзэхэд хангалттай тухай тооллогын комиссын зүгээс мэдэгдэв.

Үүний дараагаар Хархорин ХК-ийн 2019 оны 04-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тус хурлын дарга П.Бишрэл нээж үг хэлсэн ба хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлууд, эдгээр асуудлуудыг танилцуулах ажилтнуудыг танилцуулав.

(Хурлын дэгийг хавсаргасан болно)

Хурлын дарга хуралд хүрэлцэн ирсэн албан тушаалтнууд, хувьцаа эзэмшигчдийг танилцуулав.

Түүнчлэн тооллогын комиссын дарга Шавагцэрэн зүгээс санал хураалт хэрхэн явагдах, саналын хуудсаар хэрхэн саналаа өгөх талаар хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан болно.

1-р асуудал: Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн 2018 оны үйл ажиллагааны тухай ТУЗ-ийн тайланг “Хархорин” ХК-ийн Ерөнхий агрономич Л.Бямбасүрэн уншиж танилцуулсан болно. Тус тайланг бүрэн эхээр нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалд хавсаргасан.

Танилцуулсан байдал:

Л.Бямбасүрэн: Сайн байцгаана уу? Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. 2018 оны үйл ажиллагааны тухай тайланг танилцуулья.

“Хархорин” ХК-ны агроүйлдвэрлэлийн талбай нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвийн хажууд байрладаг нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд муугаар нөлөөлдөг цаг уурын огцом өөрчлөлтүүд болох мөндөр орох, шороон болон цасан шуурга шуурах, хавартаа сүүлдэж, намартаа эрт цочир хүйтрэлт болох, хяруу унах, ган гачиг болох зэрэг байгалийн бэрхшээлүүд ихээр тохиолдох магадлалыг ихэсгэдэг.

2017 – 2018 оны өвөл манай талбайд бараг цасгүй буюу 1 - 2 см орчим зузаан цастай өвөлжсөн. Гэвч хаврын эхээр гурван удаа бага зэргийн хэмжээний (5 орчим см зузаантай) цас орсноос шалтгаалан хөрс багахан хэмжээний чийгтэй байснаа хавар 4-р сарын сүүлээс эхлэн



6-р сарын дунд үе хүртэл үргэлжилсэн хаврын агаарын ган болсноос шалтгаалан энэ жил чацарганы жимст цэцэрлэгт чацарганы болон бусад жимст модлог ургамлуудад жимс дунд зэргийн хэмжээтэй суусан. Хэдийгээр зундаа хур бороо элбэгтэй байсан ч хавар чацарганы модны ид цэцэглэлтийн үед чийг нилээд дутмаг байсан нь энэ оны жимсний ургац бага байгаатай зайлшгүй холбоотой юм.

Хавар 4-р сарын эхний 10 хоногт чацарганы модны нахиа задарч эхлэдэг байхад 2018 оны 4-р сарын 19-нд эхний нахиа дөнгөж задарч эхлэсэн нь хаврын цочир хүйтрэлт болон хаврын чийгийн дутагдалтай холбоотой юм.

Хавар 5-р сард жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээх, жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээхэд зориулж хөгширч актлагдсан эр модны суулгацаас тоос хүртээх мөчир хайчлан тоос хүртээлт хийж буй бригадуудад нийлүүлэх, үхэр нүдний талбайн хярууны хамгаалалтанд бэлтгэх, хярууны хамгаалалтанд гарах, хавар шинээр тариалсан алим, чавганы суулгацын усалгааны усанд идэгдсэн тогоог засах, гадагш нийлүүлэх суулгацыг түр хадгалалтаас ухаж гарган ялган тоолж ангилаад, шошго зүүн боож ачих, орсон олон төрлийн модны хучлага авах, гүзээлзгэний арчилгаа, усалгаа, олон төрлийн модны тогооны сийрүүлэлт хийх, талбайн шижмийн хогийг бөөгнүүлэн тракторт ачих, шинээр хагалж бойжуулгад бэлтгэсэн талбайгаас чацарганы шижим түүх, тракторт чиг татаж зогсох, ТУР-ын конторын хашаанд жимсний мод тариалах, “Хархорин Шим” ХХК-ны тариан талбайд тариалалтанд ажиллах, Ротарийн хүлэмжинд хүлэмж хучих, хэмх тариалах хүлэмжүүдэд хэмх тариалах хамар хийх, ус халааж дарлага услах, дарлаганы зэрлэг авч салхилуулан арчилгаа хийх, хүлэмжний засвар үйлчилгээ хийх, мотор систем угсрах, хүлэмж хучих, хүлэмжний усалгаа хийх зэрэг цагийн ажилд нийт дүнгээрээ 5-р сард нийт агроүйлдвэрлэлийн зургаан бригадын 336,8 хүн/өдөр хүчийг дээрх цагийн ажлуудад зарцуулсан.

Мөн хавар 5-р сарын 6 – 7-ны хооронд нийт жимст цэцэрлэгийн энэ жил жимслэх ёстой 297 га талбайд гараар нэмэлт тоос хүртээх ажиллагаа хийсэн.

Намар 9-р сард аль ч талбайд намрын цэнэг усалгааны ажил хийгдээгүй.

10-р сард жимслэх ба эх цэцэрлэгийн талбай хариуцсан бригадууд талбайдаа богинохон хугацаанд боловч нөхөн тариалалт хийж, усалгаа хийсэн. Энэ ажилд “Хархорин” ХК-ны 4 бригадын 27,3 хүн/өдөр хүчээр 5685 ширхэг нөхөн тариалалтын нүх ухуулж, 34,3 хүн/өдөр хүчээр 5690 ширхэг чацарганы суулгацаар жимст ба эх цэцэрлэгийн талбайдаа нөхөн тариалалт хийлгэж, 129,4 хүн/өдөр хүчээр эх ба жимст цэцэрлэгийн 135690 метр урт шуудуугаар эх ба жимст цэцэрлэгийн нөхөн тариалалтын дараах усалгааг хийсэн.

Энэ жилийн агаарын ба хөрсний хаврын ган, зуны хэт их бороо чийгтэй байдал болон 2016 онд ихээр гарч тархан хүчтэй өвчилж (чацарганы цахлай өвчин гарсан) байсан зэргээс шалтгаалан энэ жилийн өвөл чацарганы жимс их хэмжээгээр модон дээрээ хатаж хорчийн ургацад муугаар нөлөөлсөн. Өмнөх жилүүдэд жижиг жимстэй чацарганы модны жимс огт ингэж хатаж хорчийж байгаагүй болно.

Энэ жилийн намар эрт эхлэснээс шалтгаалан чацарганы жимс эрт боловсорч эхлэсэн учир ургац хураалтыг 8-р сарын 22-с эхлэсэн.

2018 онд хурааж авсан нийт жимсний ургацын хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв.



№	Ургацын нэр	Хэмжих нэгж	Ургац хураасан хугацаа		Ургацын хэмжээ
			Эхлэсэн	Дууссан	
1	Гүзээлзгэнэ	кг	7/4/2018	8/16/2018	77,9
2	Бөөрөлзгөнө	кг	7/23/2018	9/9/2018	99,0
3	Чацаргана	кг	8/22/2018	1/6/2019	218756,86

Цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан алим, үхэр нүдний ургац гараагүй.

Хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Ганбат: Асуудал тус бүрийг уншиж танилцуулсны дараагаар Хувьцаа эзэмшигч та бүхэн өөрсдийн асуулт, санал, шүүмжлэлээ, мөн компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий агрономч, ерөнхий нягтлан бодогч нараас асууж тодруулж болно.

Иймд үйл ажиллагааны тайлантай холбоотойгоор та бүхний зүгээс асуух, тодруулах зүйл байна уу? Санал, шүүмжлэл байна уу?

П.Бишрэл: Хүлэмжинд тариалсан модны хүйсийн харьцааны тухай асуув.

Л.Бямбасүрэн: 14 хүлэмжинд эм мод, 6 хүлэмжинд эр мод тарьсан.

П.Бишрэл: талбайд гарсан хортон шавьжийг яаж устгасан тухай асуув.

Л.Бямбасүрэн: Органик жимс үйлдвэрлэхийн тулд химийн хор хэрэглэхгүйг хичээж байгаа. Энэ 2018 онд чацарганы бөөс их гарсан учир хэрэглэхээс өөр арга байгаагүй.

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах өөр зүйл гараагүй болно)

2-р асуудал: Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Тус асуудлыг нягтлан бодогч Д.Дашмаа танилцуулсан болно.

Хархорин ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалд хавсаргасан.

Д.Дашмаа: Хуралд ирсэн та бүхний амрыг айлтгая.

“ Хархорин ХК-нь өөрийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд хараат бус аудитын компани болох “ Улиастай Ван Аудит “ ХХК-р аудит хийлгэсэн болно. Тус аудитын компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос эрх авсан , итгэмжлэгдсэн аудитын компани юм. Хараат бус аудиторын зүгээс “Хархорин ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв,бодитой илэрхийлэгдсэн байна гэсэн дүгнэлтийг гаргасан. Үнэт цаас гаргагч нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2018.01.01-2018.12.31-ний байдлаар өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилладаг болно. Түүнчлэн



хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид нь "Хархорин" ХК-ийн санхүүгийн тайлантай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

"Хархорин" ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт хөрөнгө 2018 оны эхэнд 8,279,839,1 мян төг, байсан бол жилийн эцсийн байдлаар 7,721,961,1 мян төг болж 6,7% буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант оны эцэст: 3,134,884,4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй бөгөөд элэгдэл 404,252,4 мянган төгрөгийг хассан дүнгээр 2,730,632,1 мянган төгрөг.

2018 онд гаднаас худалдаж авсан буюу өөрийн үйлдвэрлэлээс орлого авсан хөрөнгө 62,233,9 мянган төгрөг байна.

Тайлант жилийн Борлуулалтын нийт орлого: 1,362,445,3 мян төг

Борлуулалтын нийт өртөг: 1,336,366,8 мян төг

Борлуулалтын ашиг: 26,078,5 мян төг

Үйл ажиллагааны бус орлого: 90,575,0 мян төг

Бусад зардал: 48,668,5 мян төг

Удирдлагын зардал: 178,914,7 мян төгрөгийг хасч тооцоод 110,929.7 мян төгрөгийн алдагдалтай ажилласан.

2018 онд байгаль цаг уурын хүндрэлтэй байдлаас шалтгаалж /бороо, хур нь хугацаа алдаж орсон / 800,0 тн ургац авахаар төлөвлөсөн боловч 178,9 тн ургац хураан авч үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа алдагдалтай ажилласан болно.

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах зүйл гараагүй болно)

3-р асуудал: 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах тухай

Энэ асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бөгөөд хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат уншиж танилцуулав.

Б.Ганбат: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02-р сарын 19 өдрийн 02 тоот тогтоолын дагуу "Хархорин" ХК нь 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. (ТУЗ-ийн тогтоолыг бүрэн эхээр нь уншиж танилцуулав)

"Хархорин" компани нь 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу 110,929.7 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан, түүнчлэн компани нь төлж барагдуулах шаардлагатай ихээхэн хэмжээний өр төлбөртэй байгаатай холбогдуулан 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Компанийн тухай хуулийн дагуу компани нь ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байхаар заасан байдаг. Өнөөдөр манай компанийн санхүүгийн нөхцөл байдал сул байгаа, ихээхэн хэмжээний өр төлбөр хуримтлагдаад байна. Ажилчдынхаа цалинг



тавих шаардлагатай байна. Та бүхэн эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэж ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг батлаж өгнө үү.

Б.Ганбат: Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-с гаргасан шийдвэрийг батлахтай холбоотойгоор та бүхний зүгээс асууж тодруулах зүйл байна уу? Санал, шүүмжлэл байна уу?

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах зүйл гараагүй болно)

4-р асуудал: “Хархорин” хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах тухай

Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Эдийн засагч, Л.Бямбасүрэн танилцуулсан болно. (Төлөвлөгөөг презентэйшн хэлбэрээр хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан болно; MS Excel хэлбэрээр хийсэн төлөвлөгөө бүрэн эхээр нь хурлын материалд хавсаргасан байгаа)

Л.Бямбасүрэн: Манай компани монголдоо №1т орох чацаргана тариалах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна. Мөн Мех баазын хашааг цементлэн грашийн барилга барих, хиймэл нуур дуслын услалтын системийн мотор байрлуулах байр барих төлөвлөгөөтэй ажиллаж байна. Жимс жимсгэнэ, газар тариалангийн бүтээгдэхүүн нэмж тариалж ургац арвин авахын төлөө ажиллаж байна. Үүнд чацаргана 730 тн-г хураан авч Живэртийн оргил ХХК болон бусад байгууллагуудад нийлүүлнэ.

Агро үйлдвэрлэлд 100 хүн цэцэрлэгчээр ажиллуулж ажлын их ачаалалтай үе буюу жимс хураалтын үед ИШША-болон бусад хамтран ажилладаг хувь хүн болон албан байгууллагуудтай хамтран ажиллана.

2018 онд үйл ажиллагаанд гарах зардал, хөрөнгө оруулалт хийх ажлуудыг товч танилцууллаа.

П.Бишрэл: жимс хураах зардлаа тооцсон уу?

Л.Бямбасүрэн. жимс ургасан байгаа нь харагдах байдлаасаа өөрчлөгддөг. Энэ нь цаг агаарын байдал, услагаа арчилгаагаас болж их өөрчлөгддөг талаар дэлгэрэнгүй тайлбарлан хэлэв.

Р.Саранцэцэг: “Хархорин” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотойгоор хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхнээс асууж тодруулах зүйл байна уу? Санал, шүүмжлэл байна уу?

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах зүйл гараагүй болно)

П.Бишрэл Ингээд санал хураалтаа эхлүүлэе.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс болон хуралд оролцсон бусад хүмүүсийн зүгээс хурлаар хэлэлцсэн асуудлуудтай холбоотойгоор тавьсан асуулт, санал, шүүмжлэл:

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг уншиж танилцуулж дууссаны дараагаар хурлын дарга тооллогын комисст хурлаар авах санал хураалтын ажиллагааг эхлүүлэхийг зөвлөв.

Тооллогын комиссын зүгээс хурлаар санал авах саналын хуудсыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хэрхэн саналаа өгөх, хуудсанд дээрх мэдээллийг хэрхэн зөв бөглөх талаар заавар өгсөн болно.

Санал хураалтыг хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан болно.



Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар өгсөн саналыг тоолох, тооллогын дүнг нэгтгэн шийдвэрээ гаргах хугацаанд хурал түр завсарласан болно.

Тооллогын дүн:

Тооллогын комиссын зүгээс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар өгсөн саналыг үндэслэн шийдвэрээ гаргаж хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулсан болно:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдээс авсан саналыг нэгтгэхэд дараах дүн гарсан болно. Үүнд:

1. Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудал – 100 хувийн саналаар батлагдав;
2. Компанийн 2018 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах – 100 хувийн саналаар батлагдав;
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах – 100 хувийн саналаар батлагдав;
4. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах – 100 хувийн саналаар батлагдав;

Хурлын дарга “Хархорин” ХК-ийн 2019 оны 04-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулав.

Хурал 16.30-д өндөрлөв.

Хурлаас гарсан шийдвэрүүд:

1. Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2018 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн зөвшөөрөв.
4. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

Хуугас 7.

**“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ толгой баг, Усжуулах 00 хаягаар барлах Компанийн өөрийн байрны хурлын танхимд болно.

1.	Хурлын ирцийг бүртгэх (тооллогын комисс)	13.30 – 14.00
2.	Хурлын ирцийг мэдээлэх (тооллогын комисс)	10 минут
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах (хурлын дарга)	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу уншиж танилцуулах	
4.1	Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай	30 минут
4.2	Компанийн 2018 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай	20 минут
4.3	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах тухай	20 минут
4.4	Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах тухай	40 минут
5.	Асуулт, хариулт, санал шүүмжлэл тавих	(асуулт тус бүрийн дараагаар)
6.	Санал хураалт (тооллогын комисс)	20 минут
7.	Хурлын завсарлага	20 минут
8.	Тооллогын комиссын санал хураалтын дүнг гаргаж танилцуулах	15 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах (хурлын дарга)	10 минут
10.	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

Хурал урьдчилсан байдлаар 4 цаг үргэлжилнэ.

“Хархорин” ХК

